

**ДУНДГОВЬ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ХӨТӨЛБӨР
/2018-2028 ОН НЭГДҮГЭЭР ҮЕ ШАТ/-ИЙГ 2019 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА
ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ
ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

2019.11.15

Дундговь аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх хөтөлбөр /2018-2028 он нэгдүгээр үе шат/-ийг 2019 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд 7 салбарын хүрээнд 48 заалт, арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусган ажилласан. Үүнийг бүлгээр нь харуулбал:


- Эрүүл мэндийн салбар – 5 заалт
- Урлагийн салбар - 13 заалт
- Биеийн тамир, спортын салбар - 11 заалт
- Үйлчилгээний салбар - 6 заалт
- Худалдааны салбар – 3 заалт
- Үйлдвэрлэлийн салбар – 7 заалт
- Тээврийн салбар – 3 заалт тус тус хэрэгжиж байна.

Дундговь аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх хөтөлбөр /2018-2028 он нэгдүгээр үе шат/-ийг 2019 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2019 оны 11 сарын 15-ны байдлаар авч нэгтгэн, Засгийн газрын 2017 оны 03 сарын 15-ны өдрийн 89-р тогтоолоор баталсан БОДЛОГЫН БАРИМТ БИЧГИЙН ХЭРЭГЖИЛТ, ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙХ НИЙТЛЭГ ЖУРАМ-д заасан үнэлгээ өгөх зааврын дагуу үнэлж үзэхэд 48 заалтын биелэлтийн явц 88.9 хувьтай хэрэгжиж байна.


Хэрэгжилтийг ангилж үзвэл:

№	Үнэлгээний төрөл	Биелэлт тоогоор	Эзлэх жин
1	“үр дүнтэй”–зорилт, арга хэмжээ нь оновчтой тодорхойлогдсон, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн, удирдлага зохион байгуулалт сайн, үр дүн гарсан бол 100 хувь (90-100 хүртэл хувь)	36	75
2	тодорхой үр дүнд хүрсэн”-зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, тодорхой үр дүн гарч эхэлж байгаа, хэрэгжилт, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай бол 70 хувь (60-89 хүртэл хувь)	6	12.5
3	“эрчимжүүлэх шаардлагатай”-зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, удирдлага, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулж, үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай бол 40 хувь (31-59 хүртэл хувь)	4	8.3
4	“үр дүнгүй”–зорилго, зорилт, арга хэмжээг илүү сайн тодорхойлох шаардлагатай, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, төсөв хөрөнгийг үр дүнтэй зарцуулж чадаагүй, удирдлага зохион байгуулалт хангалтгүй бол 0 хувь (0-30 хүртэл хувь)	1	2
5	“үнэлэх боломжгүй”-зорилго нь тодорхойгүй, шалгуур үзүүлэлт нь шаардлага хангаагүй, эсхүл шалгуур үзүүлэлттэй боловч гүйцэтгэлийг үнэлэхэд хангалттай мэдээлэл байхгүй, төсөв хөрөнгө тодорхойгүй, гадаад хүчин зүйлээс шалтгаалсан зэргийг баримтаар нотолсон бол	1	2

Хэрэгжилтийг графикаар харуулбал:



7 салбарын хэрэгжилтийг графикаар харуулбал:



2019 онд төлөвлөсөн арга хэмжээний 5 заалт буюу 10.4 хувь удаашралтай хэрэгжиж байгаа болон тасарч болзошгүй байгаа нь зохион байгуулалт болон хугацаанаас шалтгаалж байна. Энэ нь тухайн жилийн төлөвлөгөөг гаргахдаа шалгуур үзүүлэлт, хүрэх түвшин тодорхойгүй, тооцоо судалгаа байхгүй төлөвлөлт хангалтгүй хийгдсэнтэй холбоотой гэж үзэж болохоор байна.



Эрчимжүүлэх шаардлагатай байгаа болон тасарч болзошгүй заалтуудыг хэлтэс, агентлагаар нь харуулбал:

№	Хэлтэс, агентлагуудын нэрс	40 хувь	0 хувь	Тайлбар
1	ХОХБТХ	2	-	40 хувьтай 2 заалт зохион байгуулалтаас шалтгаалан удааширч байна.
2	ЭМГ	-	1	0 хувьтай байгаа 1 заалт нь зохион байгуулалтаас болж тасарч болзошгүй байна.
3	БТСГ	2	-	40 хувьтай 2 заалт нь хугацаа, зохион байгуулалтаас шалтгаалан удааширч байна.
Нийт		4	1	

Эрчимжүүлэх шаардлагатай буюу 40 хувьтай заалтууд:

№	Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин	Хэрэгжилт
1	Усан бассейн бүхий спорт цогцолбор байгуулах газрын асуудлыг шийдвэрлэн, зураг төсөв гаргах	- Спорт цогцолбор барих газрыг товлон, шийдвэр гаргах - Зураг төсөв хийх	Газрын гэрчилгээ, зураг, төсөвтэй болно.	750 Хүний суудалтай 7.2 тэр бум төгрөгний төсөвтэй спорт цогцолборын жишиг зураг төсөвтэй болсон. Аймгийн төвд Усан бассейн бүхий спорт цогцолбор байгуулах газрын асуудлыг шийдвэрлүүлэхээр Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газарт 2017-09-12-ны 66, 2019-06-07-ны 54, 2019-09-18-ны 76 тоот албан бичгүүдээр тус тус хүсэлтээ уламжилж хүргүүлсэн бөгөөд одоогоор албан ёсоор хариу ирүүлээгүй байна.
2	Аймгийн төвд хөнгөн атлетикийн болон хөл бөмбөгийн стандарт бүхий ногоон талбай байгуулах	Гэрээнд заасан хугацаанд ажлыг эхлүүлэх	Спортоор хичээллэх орчин бүрдэнэ.	Аймгийн төвд баригдаж буй Цэнгэлдэх хүрээлэнгийн барилгын гадна талбайн зураг төсөвт хөнгөн атлетикийн болон хөл бөмбөгийн стандартын ногоон талбайг байгуулахаар тусгагдсан. Зуут констракшнтай 2019 оны 8 сарын 7-нд 2,450,467,195 төгрөгийн гэрээ байгуулсан. Суурийн ажил хийгдэж байна. Ажлын гүйцэтгэл 18 хувьтай.
3	Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд логистикийн нэг цэгийн цогц үйлчилгээний цэгийг тусгуулах ажлыг зохион байгуулах	Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд логистикийн нэг цэгийн цогц үйлчилгээний цэгийг тусгуулах	Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд логистикийн нэг цэгийн цогц үйлчилгээний цэгийг тусгуулсан байна.	2019 оны 2-р сарын 28-ны өдрийн Үндэсний хөгжлийн газрын “Бүсчилсэн хөгжлийн бодлогын хэлэлцүүлэг”-т санал өгсөн боловч аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусган боловсруулсан газарт нь саналыг хүргүүлнэ гэсэн хариу өгсөн. Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд уг ажлыг тусгасан.
4	Ачаа тээврийг зохицуулах талбай, агуулахын үйлчилгээний газрыг судлан шийдвэрлэх	Газрын асуудлыг шийдвэрлэхээр холбогдох байгууллагад хандах	Газрын асуудлыг шийдвэрлэнэ.	2019 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй тул 2020 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд ШҮГ-ын хүсэлтийн дагуу ачаа тээврийг зохицуулах талбай, агуулахын үйлчилгээний газрыг Мандалговь хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд

				тусгагдсан газрыг батлуулахаар ажиллаж байна.
--	--	--	--	---

Хэрэгжилт нь тасарч болзошгүй буюу 0%-тай заалт:

№	Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин	Хэрэгжилт
1	Нэгдсэн эмнэлгийн цогцолбор барилга барих	Нэгдсэн эмнэлгийн барилгын ажлын гүйцэтгэлийн хувь	20	2019 оны 2-р улиралд Нэгдсэн эмнэлгийн 100 ортой барилгын шавийг тавьсан. 2019 онд 2,5 тэрбум төгрөг батлагдсан бөгөөд Нэгдсэн эмнэлгийн зураг төслийг Green art solution ХХК-аар гүйцэтгэхээр гэрээ байгуулан зураг төсөл хийгдэж байна.

“Үнэлэх боломжгүй” буюу хугацаа болоогүй 1 заалт:

№	Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хүрэх түвшин
1	“Нэг суурин нэг бахархал” аяныг зохион байгуулж орон нутгийн түүхий эд, нөөц баялгийг ашиглан брэнд бүтээгдэхүүнийг илрүүлэх, бий болгох	- Брэнд бүтээгдэхүүн бий болгох, шалгаруулах журам”, “Брэнд бүтээгдэхүүний лого хэрэглэх журам”-ыг боловсруулж батлуулах - “Брэнд бүтээгдэхүүн бий болгох, хөгжүүлэх”, брэнд бүтээгдэхүүний лого тэмдэг хэрэглэх эрх олгох чиглэлээр сургалт зохион байгуулах - Орон нутгийн нөөц баялаг, түүхий эдийг зүй зохистой ашиглан соёл, уламжлалыг хадгалсан, хүний эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөгүй бүтээгдэхүүнийг сурталчлах зорилгоор “Дундговьд үйлдвэрлэв” сэтгүүл гаргах - Шилдэг брэнд бүтээгдэхүүнийг шалгаруулж, брэнд бүтээгдэхүүн гэсэн лого тэмдэг олгох, батламж гардуулах	Сум бүр өөрийн бахархалт 1-ээс доошгүй бүтээгдэхүүнийг нээн илрүүлсэн байх


Дүгнэлт, зөвлөмж:

Дундговь аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх хөтөлбөр /2018-2028 он нэгдүгээр үе шат/-ийг 2019 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг 11 сарын 15-ны байдлаар авч Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 6.2, 7.1 т заасны дагуу зорилт, арга хэмжээг үнэлэхдээ шалгуур үзүүлэлт, зорилтот түвшинг хүрсэн түвшинтэй харьцуулан бодитой үнэлээг өгсөн эсэхэд явцын хяналт шинжилгээг хийлээ.

Дундговь аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх хөтөлбөр /2018-2028 он нэгдүгээр үе шат/-ийг 2019 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 48 заалт арга хэмжээг 88.9 хувьтай хэрэгжүүлж ажилласан буюу 42 арга хэмжээ нь тодорхой үр дүнд

хүрч, боломжийн хэрэгжсэн байна. Үлдсэн 12,5 хувьд эрчимжүүлэх шаардлагатай, үр дүнгүй буюу үнэлэх боломжгүй байна гэсэн үзүүлэлт гарч байгаа нь цаашид төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлэх шаардлагатай байна.

Дундговь аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх хөтөлбөр /2018-2028 он нэгдүгээр үе шат/-ийг 2019 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд явцын хяналт шинжилгээг тасралтгүй, үнэлгээг хагас бүтэн жилээр хийж ажил эрчимжүүлэх талаар зөвлөмж өгч ажилласнаар төлөвлөгөөний хэрэгжилт ахиц гарсаар байна.



Төлөвлөгөөнд туссан 48 арга хэмжээний 3 буюу 6,2 хувь нь тээврийн салбарын арга хэмжээ 70-аас доош хувьтай хэрэгжиж байна. Энэ нь зохион байгуулалтаас шалтгаалан удааширч байгаа бөгөөд төлөвлөлтөдөө анхаарч ажиллах шаардлагатай байгааг харуулж байна.

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭС